



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 07/01

Улаанбаатар хот

**Агаар, орчны бохирдлыг  
бууруулах арга хэмжээний тусгай  
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03/03 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт агаар, орчны бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээний тусгай төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. "Агаар орчны бохирдлын асуудлаарх онцгой байдлын үндэсний хороо"-ны нийслэл дэх салбар хороог шинээр байгуулж, агаар орчны бохирдлыг бууруулах нийслэлийн дэд хөтөлбөрийг "Утаагүй хот 2030" төслийн хамт боловсруулан 2017 оны 04 дүгээр сард багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  Ц.САНДУЙ

1110100003



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 07/01  
дүгээр тогтоолын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭНД АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ  
БУУРУУЛАХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУСГАЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хугацаа: 2017.01-04 дүгээр сар

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                                    | Хэрэгжүүлэх үе шатууд                                                                                                                                                                                                                              | Хэрэгжүүлэх хугацаа                     | Шаардагдах санхүүжилт /сая.төг/ | Санхүүжилтийг шийдвэрлэх эсэх                         | Хариуцан хэрэгжүүлэгч            | Хамтран хэрэгжүүлэгч              |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|---------------------------------|-------------------------------------------------------|----------------------------------|-----------------------------------|
| 1 | Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ТҮЦ, дугуй засвар, харуулын байр, автомашины засвар, угаалгын үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн дулааны эх үүсвэрт хяналт тавина. | ТҮЦ, дугуй засвар, харуулын байр, автомашины засвар зэрэг газруудын судалгааг нарийвчлан гаргана.                                                                                                                                                  | I сард                                  | -                               | -                                                     | НАББГ                            | Дүүргийн ЗДТГ                     |
|   |                                                                                                                                                                              | Судалгаанд үндэслэн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын дагуу удирдамж боловсруулан, хяналт шалгалт хийж, мэдэгдэл хүргүүлнэ.                                                                                                           | II сард -БГД, ЧД                        | 10,0                            | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ, НМХГ                      | Дүүргийн ЗДТГ                     |
|   |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                    | III сард - СБД, БЗД                     |                                 |                                                       |                                  |                                   |
|   |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                    | IV сард - СХД, ХУД                      |                                 |                                                       |                                  |                                   |
|   |                                                                                                                                                                              | Агаарын чанарыг сайжруулах бүсэд дугуй, ажилласан тос, хог хаягдал шатааж буй эсэхэд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.                                                                                                                 | II сард -БГД, ЧД                        | 8,4                             | НАББГ-ын үйл ажиллагааны зардалд тусгагдсан           | НАББГ, НМХГ, Дүүргийн ЗДТГ       | НЗДТГ, ТББ                        |
|   |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                    | III сард - СБД, БЗД                     |                                 |                                                       |                                  |                                   |
|   |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                    | IV сард - СХД, ХУД                      |                                 |                                                       |                                  |                                   |
| 2 | "Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо" аян өрнүүлнэ.                                                                                                             | Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмын танилцуулга болон нэвтрүүлэг бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж иргэдэд хүргэнэ.                                                                                                 | I, II, III, сард                        | 50,0                            | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ                            | НЗДТГ                             |
|   |                                                                                                                                                                              | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс дэх хороодын хэсгийн ахлагч нарыг орон тооны бус байцаагчаар хяналт тавьж ажиллуулна.                                                                                                                    | III, IV сард                            | -                               | -                                                     | Дүүргийн ЗДТГ                    | НЗДТГ, НАББГ                      |
|   |                                                                                                                                                                              | Иргэдийн бүлэг, хөршийн холбоо байгуулан, агаар, орчны бохирдлыг бууруулахад хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд нь нийслэл, дүүрэг, хорооноос дэмжлэг үзүүлэх, хариуцлагагүй хандсан иргэн, аж ахуй нэгжид хариуцлага тооцох тогтолцоог бий болгоно. | II сар                                  | -                               | -                                                     | Дүүргийн ЗДТГ                    | НЗДТГ, УБЗАА, НАББГ, НБОГ, НГХДБГ |
|   |                                                                                                                                                                              | Нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвд агаар, орчны бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах зорилгоор "Байгаль орчинд ээлтэй техник, технологи"-ийн үзэсгэлэн худалдааг байгуулна.                             | II сард-БЗД, Дунжингарав худалдааны төв | 30,0                            | Дүүргийн үйл ажиллагааны зардлаас тусгах              | НҮИГ, НАББГ, НБОГ, Дүүргийн ЗДТГ | НЗДТГ                             |
|   |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                    | III сард БГД-ийн ЗДТГ                   |                                 |                                                       |                                  |                                   |
|   |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                    | IV сард ХУД, Мишээл экспо төв           |                                 |                                                       |                                  |                                   |



| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хэрэгжүүлэх үе шатууд                                                                                                                                                                                                            | Хэрэгжүүлэх хугацаа                                                                                                  | Шаардагдах санхүүжилт /сая.төг/ | Санхүүжилтийг шийдвэрлэх эсэх                         | Хариуцан хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч    |
|---|---------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|-------------------------------------------------------|-----------------------|-------------------------|
|   |                           | Агаарын бохирдол хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолд сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах талаар мэдээлэл өгөх зорилго бүхий самбарыг нийслэлийн сургуулиудад байршуулна.                                   | II сард - ХУД, БЗД<br>III сард - СБД, ЧД                                                                             | 40,0                            | ОУБ ЖАЙКА санхүүжүүлнэ.                               | НАББГ                 | ЕБСургуулиуд            |
|   |                           | 2017 оны 04 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхлэх "Ахуйн хэрэглээний жижиг зуухны MNS5216:2016" стандартыг олон нийтэд хүргэх, сурталчлах, ухуулан таниулах ажлыг зохион байгуулна.                                                  | II сард Наран туул олон улсын худалдааны төв<br>III сард Хар хорин худалдааны төв<br>IV сард Бусад худалдааны захууд | 10,0                            | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | УБЦАТөсөл             | Дүүргийн ЗДТГ           |
|   |                           | Аж ахуйн нэгж, байгууллагуудад гэр хороололд амьдардаг ажилтнууддаа утаагүй технологи хэрэглэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд уриалга гаргана.                                                                                | II сард 50 аж ахуйн нэгж<br>III сард 50 аж ахуйн нэгж                                                                | -                               | -                                                     | НАББГ                 | НЗДТГ                   |
|   |                           | Агаарын чанарыг сайжруулах 3, 4 дүгээр бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудад стандартын шаардлага хангасан цахилгаан болон хийн халаагуураар халаалтаа шийдвэрлэх тухай албан шаардлага, мэдэгдэл хүргүүлнэ. | II, III сард                                                                                                         | 10,0                            | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ                 | Дүүргийн ЗДТГ, НМХГ     |
|   |                           | Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор дулаан хуримтлуулж, халаах төхөөрөмж болон бусад шинэ технологи, тоног төхөөрөмжийг иргэдийн хэрэглээнд нэвтрүүлнэ.                                                                        | II сард 1-р бүс<br>III сард 2-р бүс                                                                                  | 1 000,0                         | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ                 | Дүүргийн ЗДТГ           |
|   |                           | Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч буй зорилтот бүлгийн иргэдийг 500 тн сайжруулсан түлшээр хангана.                                                                                                                       | II сард                                                                                                              | 100,0                           | БОАЖЯ шийдвэрлэнэ.                                    | НХҮГ                  | НЗДТГ, НАББГ            |
| 3 |                           | Гэр хороололд хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх талаар харилцаат хотуудтай хамтран ажиллах санал тавина.                                                                                                      | II сард                                                                                                              | -                               | -                                                     | ГХДБГ                 | НЗДТГ                   |
|   |                           | Нийслэлийн өмчийн барилгын эрчим хүчний хангамжийг байгальд ээлтэй хүчний эх үүсвэрээр хангах ажлыг эрчимжүүлнэ.                                                                                                                 | II, III, IV сард                                                                                                     | 1 000,0                         | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ                 | НЗДТГ, УБЗАА, УБЦАТөсөл |



| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                | Хэрэгжүүлэх үе шатууд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Хэрэгжүүлэх хугацаа | Шаардагдах санхүүжилт /сая.төг/ | Санхүүжилтийг шийдвэрлэх эсэх                         | Хариуцан хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч        |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|---------------------------------|-------------------------------------------------------|-----------------------|-----------------------------|
|   |                                                                                                                          | Цахилгаан халаагуурт чанарын гэрчилгээ олгож, гэрчилгээжсэн аж ахуй нэгжүүдийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааг нь сурталчлан дэмжинэ.                                                                                                                                                                                                                                                                | III, IV сард        | -                               | -                                                     | УБЗАА                 | НЗДТГ, НАББГ, НМХГ          |
|   |                                                                                                                          | Агаарын сайжруулах бүс дэх аж ахуйн нэгж, орон сууцны хотхон, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын газруудад хийн болон цахилгаан зуухыг хэрэглээндээ нэвтрүүлэх арга хэмжээг авна.                                                                                                                                                                                                                                           | IV сард             | -                               | -                                                     | НАЖГ, НАББГ           | УБЗАА, Дүүргийн ЗДТГ        |
|   |                                                                                                                          | Агаарын бохирдлыг бууруулах шинэ техник, технологи төхөөрөмжийг нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн эх үүсвэрийг бага хүүтэй урт хугацаат дотоод, гадаадын зээл, тусламжаар шийдвэрлэж, технологийн шинэчлэлтэй холбоотой гарсан зардал, хөрөнгө оруулалтыг тухайн хэрэглэгч, нийлүүлэгчийн цахилгааны төлбөр дээр бага хэмжээгээр олон жилийн турш нэмж суутгах санхүүгийн арга хэрэгслийг нэвтрүүлнэ. | III сард            | -                               | -                                                     | НГХДБГ                | НЗДТГ, УБЗАА                |
| 4 | Гэр хороололд байрлалтай сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тодорхойлох судалгаа хийж, төслийг эхлүүлнэ. | Гэр хороололд байрлалтай 50 цэцэрлэгт 200 ширхэг агаар цэвэршүүлэгч ХЕПА шүүлтүүр, агаарын чанар хэмжигч лазер төхөөрөмжийн хамт нийлүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                   | I, III сард         | 180,0                           | УБЦАтөслийн санхүүжилт                                | НАББГ                 | НЗДТГ, УБЦАтөсөл            |
|   |                                                                                                                          | Сургууль, цэцэрлэгийн дулаан техникийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | III сараас          | 120,0                           | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | УБЗАА                 | -                           |
|   |                                                                                                                          | Олон улсын стандартыг хангасан амны хаалтыг агаарын чанарын 1-р бүсийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй олгоно.                                                                                                                                                                                                                                                                                                         | II, III сард        | 50,0                            | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ                 | НЗДТГ                       |
| 5 | Улаанбаатар хотыг ерөнхий төлөвлөгөөтэй "Агаарын бохирдлыг мастер төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлнэ.                      | Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | II сард             | 100,0                           | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | ННЗБ-ууд, НАББГ       | НЗДТГ, ОУБ-ууд              |
|   |                                                                                                                          | Ажлын хэсгээс гарсан зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө боловсруулах эрдэмтэн судлаачдын багийг сонгон шалгаруулна.                                                                                                                                                                                                                                                                                                               | II, III сард        |                                 |                                                       | ННЗБ-ууд, НАББГ       | НЗДТГ, ОУБ-ууд              |
| 6 | 100кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд итгэмжлэл хийнэ.                                                        | 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зууханд магадлан итгэмжлэлийг явуулна.                                                                                                                                                                                                                                                                                                                                          | II сард - БГД, ЧД   | 12,0                            | НАББГ-ын үйл ажиллаганы зардалд тусгагдсан.           | НМХГ                  | НАББГ, УБЗАА, Дүүргийн ЗДТГ |
|   |                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | III сард-СБД, БЗД   |                                 |                                                       |                       |                             |
|   |                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | IV сард-СХД, ХУД    |                                 |                                                       |                       |                             |
|   |                                                                                                                          | 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын 20 зуухны хаягдал утаанд хэмжилт хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                         | II сард -БГД, ЧД    |                                 |                                                       | НАББГ                 | -                           |
|   |                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | III сард - СБД, БЗД |                                 |                                                       |                       |                             |
|   |                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | IV сард - СХД, ХУД  |                                 |                                                       |                       |                             |



| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                          | Хэрэгжүүлэх үе шатууд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Хэрэгжүүлэх хугацаа | Шаардагдах санхүүжилт /сая.төг/ | Санхүүжилтийг шийдвэрлэх эсэх                         | Хариуцан хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч    |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|---------------------------------|-------------------------------------------------------|-----------------------|-------------------------|
|   |                                                                                                                                                                    | Агаарын чанарыг сайжруулах 1, 2-р бүс дэх төрийн болон орон нутгийн өмчит газрын харьяа байгууллагуудын нам даралтын зуухнуудыг филтэртэй болгох, Улаанбаатар хотын харьяа байгууллагуудын нам даралтын зууханд нийслэлээс санаачлан, хөрөнгийг шийдэж филтэр тавих ажлыг зохион байгуулж, 2017 онд багтаан хувийн хэвшлийн байгууллагуудад нам даралтын зуухнууддаа филтэр тавих ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийх шаардлага тавьж хэрэгжүүлнэ. | II сараас           | 1 000,0                         | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НАББГ                 | ХИХУГ                   |
|   |                                                                                                                                                                    | Халаалтын зуухны судалгаа гаргаж, төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн сүлжээнд үе шаттайгаар холбох ажлыг эхлүүлнэ. /2В магистраль, хилчин хотхон/                                                                                                                                                                                                                                                                                           | IV-IX сард          | 6 700,0                         | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | УБЗАА                 | НМХГ, НХТЭТГ, УБДС ТӨХК |
| 7 | Нийслэлийн нутаг дэвсгэрт шатахуун импортлогч, түгээх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлагад хяналт, шалгалт хийнэ. | Нефтийн бүтээгдэхүүн импортлогч 10 аж ахуй нэгжийн 10 агуулах, 30 шатахуун түгээх станцаас дээж авч, чанар стандартын байдалд хяналт шалгалт хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                          | II, III, IV сард    | 7,5                             | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НМХГ                  | НТГ                     |
| 8 | Цахилгаан эрчим хүчний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллана.                                                                                           | Их тойруу 110 кВт шугамыг яаралтай ашиглалтад оруулна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | IV сард             | -                               | -                                                     | УБЗАА                 | ЭХЯ                     |
|   |                                                                                                                                                                    | Улаанбаатар хотод 2 тарифт тоолуургүй 36.458 айл өрхийг тоолууржуулна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | III-IV сард         | -                               | -                                                     | УБЦТС                 | УБЗАА                   |
|   |                                                                                                                                                                    | Гэрэл цахилгаангүй нийт 5.800 айл өрхийг цахилгаан эрчим хүчинд шинээр холбох, 4.0 квт-ын цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                         | V сард              | 7 350,0                         | Улсын төсөвт тусгагдсан.                              | УБЗАА                 | ЭХЯ, УБЦТС              |
|   |                                                                                                                                                                    | Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүчний хэрэглээний судалгааг гаргаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудад саналаа хүргүүлж, хамтран ажиллана.                                                                                                                                                                                                                                                                                              | IV сард             | -                               | -                                                     | УБЗАА                 | НЗДТГ, УБЦТС, НХТЭТГ    |
|   |                                                                                                                                                                    | Шинэ эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох ажлыг эрчимжүүлэх хүсэлтийг Эрчим хүчний яам болон холбогдох байгууллагуудад уламжилж хамтран ажиллана.                                                                                                                                                                                                                                                                                            | II сард             | -                               | -                                                     | УБЗАА                 | НЗДТГ, НАББГ            |
|   |                                                                                                                                                                    | Шөнийн тарифын хөнгөлөлтийг Нийслэлийн 9 дүүрэгт ижил тэгш хэрэгжүүлэх боломжийг судална.                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | III сард            | -                               | -                                                     | НАББГ                 | УБЗАА, ЭХЯ              |



| №  | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                                                        | Хэрэгжүүлэх үе шатууд                                                                                                                                                                                                                                                                                        | Хэрэгжүүлэх хугацаа | Шаардагдах санхүүжилт /сая.төг/ | Санхүүжилтийг шийдвэрлэх эсэх                         | Хариуцан хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|---------------------------------|-------------------------------------------------------|-----------------------|----------------------|
| 9  | Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаанд үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үе шаттай арга хэмжээ авна.                                             | Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолын дагуу нийт 1168 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын ээлжит үзлэгт бүрэн хамруулна.                                                                                                                                                                           | II, IV, IX, X сард  | 2,0                             | Нийслэлийн 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх | НТГ                   | НЗДТГ, ЗЦА, ЗТХЯ     |
|    |                                                                                                                                                                                                  | Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож байгаа том оврын автобуснуудын утаанд хэмжилт, судалгааны ажлыг хийж, зөрчлийг арилгана.                                                                                                                                                                          | I, II, III, IV сард |                                 |                                                       |                       |                      |
|    |                                                                                                                                                                                                  | Том оврын автобусанд бохирдол бага гаргадаг түлш хэрэглүүлэх, яндангийн шүүлтүүр тавина.                                                                                                                                                                                                                     | II, IV сард         | -                               | -                                                     | НТГ                   | НЗДТГ, НМХГ          |
